



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/492

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн бага боловсролын Бэлтгэл хөтөлбөрийг нэгдүгээр, Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, Математикийн сургалтын хөтөлбөрийг гуравдугаар, Яриа бичгийн сургалтын хөтөлбөрийг дөрөвдүгээр, Биет зүйлийн сургалтын хөтөлбөрийг тавдугаар, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн захирал /Б.Батсайхан/-д даалгасугай.

3. Сонсголын бэрхшээлтэй 29 дүгээр тусгай сургуулийн Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Л.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 26 сарын 26 өдөр /2018/492  
тоот туурвалын хавсаргалт

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН 29 ДҮГЭЭР  
ТУСГАЙ СУРГУУЛИЙН "БЭЛТГЭЛ" ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ

Үндэсний хэмжээнд сургалтын үйл ажиллагаа явуулдаг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургууль нь үндсэн чиг үүргийн хувьд сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ерөнхий боловсрол болон мэргэжлийн чиг баримжаа олгодог сургууль болно.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуульд сүүлийн 3 жилд I ангид нийт 98 сурагч элсэн суралцсанаас сонсголгүй 51 сурагч, сул сонсголтой 12 сурагч, хэл ярианы бэрхшээлтэй 10 сурагч, хавсарсан бэрхшээлтэй 19 сурагч байна. Эдгээр суралцагчдын 80 гаруй хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй, нийт элсэгчдийн 50 гаруй хувь нь хөдөө, орон нутгаас элсэн суралцаж байгаагаас үзвэл эдгээр суралцагчид нь ЕБС-д элсэн суралцах бэлтгэл хангагдаагүй сургуульд элсэн суралцаж байна.

Иймээс тус сургуулийн нэгдүгээр ангид шинээр элсэгчид нь гэр бүл, нийгэм, соёлын өөр өөр орчинд өссөн тул зан араншин, сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, эрүүл мэнд болон сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд харилцан адилгүй, ялгаатай байгаа нь тухайн суралцагчид амьдралын шинэ орчин(сургууль, анги, дотуур байр, нийслэл хот)-д "суралцах" үйл ажиллагаанд оролцоход хүндрэлтэй байдлыг үүсгэж, суралцахуйн үйл ажиллагаанд дараах бэрхшээлүүд үүсгэж байна. Үүнд:

- Сургууль, анги танхимын орчин, сургалтын үйл ажиллагааны дэгд дасахгүй байх;
- Дохионы хэл мэдэхгүй тул багш болон бусадтай харилцаж чадахгүй;
- Нарийн цагийн хуваарь бүхий шинэ харилцаанд оролцох, олон хүнтэй харилцах;
- Дотуур байрны амьдралын хэв маягт дасахгүй байх;
- Аав ээж болон гэр бүл, гэр орноо санах;
- Өөрийгөө илэрхийлэх, өөртөө үйлчлэх хэрэгцээ үүсэх;
- Сургуульд бэлтгэгдсэн байдал харилцан адилгүй байх;
- Гэр бүлийн гишүүд дохионы хэл мэдэхгүй;
- Сонсгол, хэл ярианы бэрхшээл, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй зэргээс зурах, бичих, цээжлэх, тогтоох, гэрийн даалгавар хийх үйлийг гүйцэтгэж чадахгүй сэтгэл санааны тавгүй байдалд орох;
- Ниймгийн зарим нэгэн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх;
- Өөрсдийнх нь тоглох, зурагт үзэх зэрэг дуртай зүйлээ хийх цаг хугацаа багасахад дургүйцэх гэх мэт.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд сургуульд элсэн суралцахад бэрхшээл үүсгэж байгаа хүчин зүйлсийг аль болох богино хугацаанд засан сайжруулах, сургууль, дотуур байрны орчинд дасан зохицох, суралцахад бэлтгэх, суралцах анхан шатны арга барил эзэмших, өөрийгөө илэрхийлэх, өөртөө үйлчлэх энгийн чадвартай болгох зорилгоор "Бэлтгэл" хөтөлбөрийн судлах цагийг нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөөнд 80 цагаар тусган хэрэгжүүлж байгаа тул хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.